БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/1/НА-СТА-ОНӨААН

Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayrd@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodol@audit.gov.mn

Аудитор: А.Сувдаа
Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn
Булган хот
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан 5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 6
3. Аудитын тайлан 8
3.1 Ерөнхий зүйл 8
3.2 Дотоод хяналт 8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 8
3.4 Материаллаг байдал 8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа 9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин 9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого 10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 11
5.1 Шилэн дансны мэдээлэл 11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал 13
8. Аудитын илрүүлэлт 13
8.1 Залруулсан алдаа 13
8.2 Төлбөрийн акт 14
8.3 Албан шаардлага 14
8.4 Зөвлөмж 15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 0

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.03.15 № 254

танай_____ны №_____т

"ИЛЧИТ ХУТАГ" ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ШИНЭБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын "Илчит-Хутаг" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын "Илчит-Хутаг" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Сумын ИТХ-ын 2014 оны 35 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант оны борлуулалтын өртгийг тооцохдоо үйлдвэрлэлд хамаарах зардлын дүнгээр бус зөвхөн бараа материалын зарцуулалт 105,642.3 мянган төгрөгөөр тодорхойлсон, ИТХ-ийн шийдвэргүй 7,800.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, жилийн эцсийн тооллогыг үнэн зөв чанартай хийгээгүй, 2020 оны санхүүгийн тайлангаар дүгнэлт өгөхөөс татгалзсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн

D:/bichighereg/2022A4toot

006020340

тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4-т заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв болон тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудал

Батлагдсан орон тоонд хүний нөөц, дотоод хяналтын албан хаагчийг байхаар баталсан ч дотоод хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, гүйцэтгэлийг тооцоогүй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дулааны болон хог тээвэрлэлтийн орлогыг аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхөөс гэрээ байгуулан авч байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

6317144798
ГЮА0048 3190269

D:/bichighereg/2022A4toot

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 01-р сарын 01	2021 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	26,699,827.02	24,295,082.79
1.1.2	Дансны авлага	13,329,003.24	19,913,171.22
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	183,469.10
1.1.4	Авлага	13,329,003.24	19,913,171.22
1.1.6	Бараа материал	16,173,866.00	24,447,339.69
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	56,202,696.26	68,655,593.70
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,006,908,286.51	3,987,616,633.75
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,006,908,286.51	3,987,616,633.75
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,063,110,982.77	4,056,272,227.45
2.1.1.1	Дансны өглөг	-	1,588,561.23
2.1.1.7	ААНОАТ өр	670,131.50	-
2.1.1.9	НӨАТ	-	24,150.91
2.1.1.10	ХАОАТ	-	610,634.39
2.1.1.11	Богино хугацаат өр	121,735.48	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	791,866.98	2,223,346.53
2.2	Өр төлбөрийн нийт дүн	791,866.98	2,223,346.53
2.3	Эздийн өмч	4,405,291,861.00	4,405,291,861.00
2.3.1	Өмч: - төрийн	4,405,291,861.00	4,405,291,861.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,378,191.00	20,378,191.00
2.3.8	Хуримтлагдсан ашиг	(363,350,936.21)	(371,621,171.08)
2.3.9	Тайлант үеийн ашиг		(8,270,234.87)
2.3.10	Өмнөх үеийн ашиг	(363,350,936.21)	(363,350,936.21)
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,062,319,115.79	4,054,048,880.92
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,063,110,982.77	4,056,272,227.45

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	570,692,603.19
2	Борлуулалтын өртөг	105,642,271.27
3	**Нийт ашиг (алдагдал)**	**465,050,331.92**
4	Бусад орлого	120,997,000.00
5	**Орлогын дүн**	**120,997,000.00**
6	Борлуулалт, маркетингийн зардал	496,143.03
7	Ерөнхий ба удирдлагын зардал	592,893,403.76
8	Бусад зардал	928,020.00
9	**Зардлын дүн**	**594,317,566.79**
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(8,270,234.87)
11	Татварын дараах ашиг (алдагдал)	(8,270,234.87)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(8,270,234.87)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний	Гадаад валютын хөрвүүлэлт	Эздийн өмчийн бусад	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл								
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)								
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,405,291,861.0			20,378,191.0			(363,350,936.2)	4,062,319,115.8
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
11	Залруулсан үлдэгдэл	4,405,291,861.0						(363,350,936.2)	4,041,940,924.8
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(8,270,234.9)	(8,270,234.9)
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт								-
15	Зарласан ногдол ашиг								-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
17	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,405,291,861.0	-	-	-	-	-	(371,621,171.1)	4,033,670,689.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31
1	Мөнгөн орлогын дүн (+)	618,525,978.55
1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	567,004,136.37
1.2	Бусад мөнгөн орлого	51,521,842.18
2	Мөнгөн зарлагын дүн (-)	620,930,722.78
2.1	Ажиллагчдад төлсөн	172,803,815.00
2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,122,017.39
2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	128,216,622.61
2.4	Ашиглалтын зардалд төлсөн	510,779.09
2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	123,471,365.41
2.6	Татварын байгууллагад төлсөн	66,922,724.89
2.7	Бусад мөнгөн зарлага	75,883,398.39
3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,404,744.23)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,404,744.23)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,699,827.02
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,295,082.79

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Борлуулалтын орлого /НӨАТ ОРСОН/	615,934,619.00	721,147,149.09	105,212,530.09
2	НӨАТ	55,994,056.00	47,149,334.55	(8,844,721.45)
3	НӨАТ БУЦААЛТ	20,937,323.00	17,691,788.65	(3,245,534.35)
4	ЦЭВЭР БОРЛУУЛАЛТ	580,877,886.00	691,689,603.19	110,811,717.19
5	Цалин	192,202,000.00	175,484,073.68	(16,717,926.32)
6	НДШ	25,947,270.00	51,830,342.39	25,883,072.39
7	Нүүрс ХА	34,438,010.00	44,069,400.00	9,631,390.00
8	Нүүрс тээвэр	95,019,221.00	126,121,820.00	31,102,599.00
9	Цахилгаан	58,770,000.00	53,190,320.00	(5,579,680.00)
10	Шатахуун, тослох материал	13,500,000.00	14,135,318.00	635,318.00

11	Засвар	17,000,000.00	19,709,128.28	2,709,128.28
12	Сэлбэг	4,750,000.00	4,840,000.00	90,000.00
13	Хөдөлмөр хамгаалал	12,238,400.00	8,657,000.00	(3,581,400.00)
14	Ажилчдын хоол	5,600,000.00	10,122,760.00	4,522,760.00
15	Бичиг хэрэг	604,000.00	571,530.00	(32,470.00)
16	Харилцаа холбоо	1,617,600.00	1,200,000.00	(417,600.00)
17	Сургалт	1,550,000.00	520,000.00	(1,030,000.00)
18	БО, тусгай зөвшөөрөл, авто татвар	9,174,200.00	9,959,147.39	784,947.39
19	ОН тохижилт үйлчилгээ	15,040,000.00	12,521,641.02	(2,518,358.98)
20	Томилолт	940,000.00	1,235,000.00	295,000.00
21	Байгаль орчин	1,900,500.00	1,448,000.00	(452,500.00)
22	Дулаан үйлдвэрлэл ажилчдын ур чадвар урамшуулал	7,320,000.00	7,320,000.00	-
23	Дотоод журамд заасан тэтгэмж, тусламж	1,900,000.00	2,067,250.00	167,250.00
24	ажилчдын идэвхижүүлэлт	1,380,000.00	1,380,000.00	-
25	Элэгдлийн зардал	49,323,164.00	153,327,107.30	104,003,943.30
26	Болзошгүй зардал /Нийт зардал 0.5%/	2,751,072.00	250,000.00	(2,501,072.00)
27	Үйл ажиллагааны нийт зардал	552,965,437.00	699,959,838.06	146,994,401.06
28	ТТӨА	27,912,449.00	(8,270,234.87)	(36,182,683.87)
29	ААНОАТ	2,791,244.90		
30	Цэвэр ашиг	25,121,204.10		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад 2021 оны санхүүгийн тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 28-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Дотоод хяналтын ажилтны хэрэгжүүлсэн ажлын баримт байхгүй аман хэлбэрээр ажлыг гүйцэтгэсэн байна.

Тус ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгийн 4,063,110.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 60,946.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хутаг-Өндөр сумын "Илчит Хутаг" ОНӨААТҮГ-ын зорилго нь төвлөрсөн дулааны шугамд холбогдсон ААН, байгууллага, айл өрхүүдэд дулааны эрчим хүчийг найдвартай, тасралтгүй дамжуулж, дулаанаар хангах зорилготой. Байгууллагын үндсэн чиг үүрэг нь дулаан үйлдвэрлэх, дулаан дамжуулах, дулаанаар хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цэвэр бохир усан хангамжийг бий болгох, усыг түгээх, ашиглалт, засвар үйлчилгээг хангах, дулаан түгээх, дулаан зохицуулах, засварлах, дагалдах ажил болон сумын төвийн хуурай хог хаягдлыг стандартын хүрээнд зайлуулах, үйлдвэрийн газар нь үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг явуулж орлого ашгаа нэмэгдүүлэх гэж тодорхойлжээ.
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит ААТҮГ статустай байна.
Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хутаг-Өндөр сумын "Илчит Хутаг" ОНӨААТҮГ нь сумын ИТХ-ын 2014 оны 35 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ИТХ, гүйцэтгэх захирлыг сумын Засаг дарга томилж байгаа нь Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль 20.1.13, 29.2, ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 5, ИТХ-ийн 2014 оны "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ын дүрмийн 5.10.4, 6.4-д заасантай нийцсэн байна.

Хутаг-Өндөр сумын "Илчит Хутаг" ОНӨААТҮГ-ын эрх барих дээд байгууллага нь сумын ИТХ байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.0 төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна. Энэ хүрээнд тодорхой ажлыг зохион байгуулж арга хэмжээ аваагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулаагүй, байна.
Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,699.8	24,295.1	(2,404.7)
БХХО	-	-	-
Авлага	13,329.0	19,913.2	6,584.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	16,173.9	24,447.3	8,273.5
Үндсэн хөрөнгө	4,006,908.3	3,987,616.6	(19,291.7)
Биет бус хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгийн дүн	**4,063,111.0**	**4,056,272.2**	**(6,838.8)**
Өр төлбөрийн дүн	791.9	2,223.3	1,431.5
Богино хугацаат өглөг	791.9	2,223.3	1,431.5
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	4,062,319.1	4,054,048.9	(8,270.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**4,063,111.0**	**4,056,272.2**	**(6,838.8)**

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 24,295.1 мянган төгрөг Хаан банк, Төрийн банканд байна.

Мөнгөтэй адилтгах хөрөнгөгүй байна.

Авлагын үлдэгдэлд дансны авлага 17,151.4 мянган төгрөг, НДШ-ийн авлага 183.5 мянган төгрөг, ажилчдаас авах авлага 2,578.3 мянган төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс татвар, ажилчдын цалин, төрөөс үзүүлсэн дулааны хөнгөлөлтийн хүрээнд үүссэн татвар, ажилчид, Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс авах авлага нийт 6,584.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд 13,329.0 мянган төгрөгийн найдваргүй авлага үүсэж болзошгүй авлага байна. Найдваргүй авлагыг тооцоолох арга тодорхой бус, найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24,447.3 мянган төгрөг болж 8,273.5 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалтаас бага зарцуулалт хийснээс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 114,294.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Оны эцэст 8,524.1 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь дулаан түгээх, дулааны үйлдвэрлэлийг алдагдуулахгүйгээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 119,100.0 мянган төгрөгөөр, шинээр өөрийн хөрөнгөөр 14,935.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ИТХ-ийн шийдвэрээр 6,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан

борлуулсан, тайлант хугацаанд 153,327.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд дансны өглөг, НӨАТ, ХХОАТ-ын нийт 2,223.3 мянган төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлгүй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүйгээс зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг хэрхэн зөвшөөрч тусгах нь тодорхойгүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалт, маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бараа материалын зарцуулалтыг хамруулсан байна. Үүнээс хүнс, хангамжийн материал, бичиг хэргийн зардлууд өртөгт хуваарилагдахгүй зардлууд байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хутаг-Өндөр сумын ИТХ-ын 2020 оны 2/09 дугаар тогтоолоор ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 580,877.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 552,965.4 мянган төгрөгөөр, 25,121.2 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 15,040.0 мянган төгрөгийг төлөвлөсөн бөгөөд тодотгол хийгдээгүй байна.

Гүйцэтгэлээр 691,689.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 699,959.8 мянган төгрөгийн зардал гарган, 8,270.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 691,689.6 мянган төгрөг болж төлөвлөснөөс 110,811.7 мянган төгрөг буюу 19.1 хувиар нэмэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 119,100.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 699,959.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 146,994.4 мянган төгрөг буюу 26.6 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант хугацааны элэгдлийн зардлыг 104,003.9 мянган төгрөгөөр дутуу тооцсон, засварын зардал, нүүрс худалдан авах зардлыг дутуу тооцоолсноос гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 15,040.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 8,270.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 33,391.4 мянган төгрөгөөр дутуу байгаа нь зардлын тооцоолол дутуу, зарим зардлыг төлөвлөснөөс илүү зарцуулсан нь нөлөөлж байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан local.audit.mn цахим бүртгэлийн хүрээнд мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хутаг-Өндөр сумын "Илчит Хутаг" ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 814,473.4 мянган төгрөгийн 84 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 16 удаагийн 176,178.8 мянган төгрөгийн орлого, 13 удаагийн 85,766.2 мянган төгрөгийн зарлага, 13 удаагийн 54,439.8 мянган төгрөгийн худалдан авалтын мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 3.1-д төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээ авч ажиллах болон ТБОНӨХБАҮХАТ хуулийн зохицуулалттай.

Аудитаар тус ОНӨААТҮГ-т дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ИТХ-аас төсөвт тодотгол хийгээгүй, гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 14-ний Б/26, 2021 оны 12 дугаар сарын 10-ны Б/21 дүгээр тушаалаар албан хаагчдад нийт 6,600.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д заасныг хэрэгжүүлж хэмнэлттэй ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

2. Сахилгын шийтгэлтэй машинист болон цахилгаанчин 2 албан хаагчдад 800.0 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", дотоод журмын 11.6-д "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 6 сарын дотор уг ажилтанд хөдөлмөрийн дотоод журамд заасан шагнал, урамшуулал олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

   Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй ажилтан, албан хаагчдад Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчин шагнаж урамшуулсан 800.0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох, Төлбөрийн акт тогтоох

3. Түүхий эд материал болох нүүрсийг "Баян тээг" ХХК-иас тайлант онд нийт 44,069.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн бөгөөд нүүрсний тээвэрлэлтэд нийт 123,205.6 мянган төгрөгийн тээврийн хөлс олгосон ч гүйцэтгэсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй гэрээ хийгээгүй шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", байгууллагын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.5-д , нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

   Шийдвэрлэсэн нь:Таслан зогсоох, хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага өгөв.

4. ИТХ-ын шийдвэргүйгээр 7,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл бэлтгэсэн нь байгууллагын дүрмийн 4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, ТБОНӨТХ-ийн 20

дугаар зүйл “Зөвлөлийн гишүүд захиралд гагцхүү зөвлөх эрхтэй ажиллана”, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Таслан зогсоох, холбогдох хууль, дүрмийг бүрэн хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

5. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй худалдан авалт хийсэн, худалдан авагч 27 байгууллага, харилцагч 23 байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй нь НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 7 дугаар зүйлийн 7.3.1-д "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ", 17.3.3-т "хэрэглэгчийн системд бүртгэгдсэн төлбөрийн баримтын мэдээллийг гурав хоногийн дотор багтаан борлуулалтын нэгдсэн системд илгээнэ", 17.3.4-т "албан татвар суутган төлөгч хоорондын бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг баталгаажуулсан нэмэгдсэн өртгийн албан татварын падааны бүртгэлийг холбогдох мэдээллийн санд оруулж, мэдээллийг 7 хоногт багтаан нэгдсэн системд илгээнэ" 17.4-т "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй"заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Таслан зогсоох, холбогдох хууль, дүрмийг бүрэн хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Татгалзах дүгнэлт авсан бөгөөд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй болно.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 200,824.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 83,353.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,461.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 25,762.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 90,247.1 төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 117,470.8 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 60,946.7 мянган төгрөгийн түвшнээс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 83,353.7 төгрөгийн 4 алдааг залруулаа. Үүнд:

- Төлбөрийг дараа өгөхөөр 24,411.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа бүртгэлийг өглөг үүсгэхгүйгээр авлага бууруулах бичилт хийсэн нь УСНББОУС 12 болон Сангийн сайдын 2018 оны 100 дугаар журам,
- Цалинг тооцон бүртгэхдээ тооцоолсон дүнгээр бүртгээгүй, илүү 8.610,0 мянган төгрөгөөр журнал бүртгэл хөтөлсөн,
- Данс бүртгэлд тусгагдсан үндсэн хөрөнгийн 431,8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу бүртгэсэн, 49,900.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого дутуу нь УСНББОУС 17 зэрэг нь тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна

8.2 Төлбөрийн акт

1. Гүйцэтгэх захирлын 2021.04.13-ны Б/21 тоот тушаалаар батлагдаагүй орон тоонд аж ахуйн нярав авч ажиллуулан 464.3 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны 2/09 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Батлагдаагүй орон тооны ажилтанд олгосон 464.3 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох, Төлбөрийн акт тогтоох

2. Илүү цагийн тооцоололд түүвэрлэн тооцоолоход ээлжийн бус 12 ажилтан албан хаагчид илүү цаг тооцон олгохдоо Засгийн зарын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3-ын 3-т зааснаас илүү олгосон байна.

Энэ нь Засгийн зарын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3-ын 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс 977.0 мянган төгрөгийг илүү олгосон, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 977.0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох, Төлбөрийн акт тогтоох

8.3 Албан шаардлага

1. Төрөөс үзүүлсэн хөнгөлөлтийн үнэ болох усны үнэ 3,734.0 мянган төгрөг, дулааны үнэ болох 25,965.4 мянган төгрөг, нийт 29,699.4 мянган төгрөгийг тухай бүр авлагаар бүртгэл хөтлөөгүй, жилийн эцэст үүссэн 3,936.9 мянган төгрөгөөр авлага үүсгэсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ, 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, ..." 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг таслан зогсоох, Албан шаардлага өгөх.

2. Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын А/7 тоот тушаалаар 12 дугаар сарын 28-нд дуусгахаар 4 хүний бүрэлдэхүүнтэй жилийн эцсийн тооллогын комиссыг томилжээ. Тооллогын дүнгээс үндсэн хөрөнгө 175,699.5 мянган төгрөгөөр, бараа материал 3,952.4 мянган төгрөгийн дутуу, тооллого хийснээс хойш бараа материал 11,925.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн нь тооллогыг үнэн зөв бодиттой хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг таслан зогсоох, Албан шаардлага өгөх.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:
Тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс тайлант хугацаанд 6,584.2 мянган төгрөгийн авлага үүсэж, өмнөх онд үүссэн 4,100.6 мянган төгрөг, 4-5 жилийн насжилттай 9,228.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:
Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16.5.4-т заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:
Бараа материалыг орлогоор бүртгэхдээ эхний хагас жил НӨАТ орсон дүнгээр нярав орлого авч тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын 4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:
Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын 4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:
Тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс тайлант хугацаанд 2,223.3 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:
Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16.5.4-т заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

4. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны борлуулалтын өртгийг тооцохдоо үйлдвэрлэлд хамаарах зардлын дүнгээр бус зөвхөн бараа материалын зарцуулалт 105,642.3 мянган төгрөгөөр тодорхойлсон байна.

Энэ нь Өртгийг үнэн зөв тооцоолоогүй нь Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаал, үнэлгээ ба хуваарилал, ангилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:
Холбогдох хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

5. *Зардалтай холбоотой асуудал*

Илрүүлэлт:
Дотоод журмын 6.2-т ажилтан албан хаагчдын цагийн бүртгэлийг тухайн сарын 25-нд гаргаж цалинг тооцоолж шилжүүлж тайлагнасан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно", байгууллагын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:
НББ-ийн тухай хуулийн 10.1, байгууллагын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

6. *Бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал*

Илрүүлэлт:
Тус ОНӨААТҮГ нь өөр үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс өртөг тооцоолол, журнал бүртгэл буруу хөтлөгдөх үндэслэл болж байна.

Өгсөн зөвлөмж:
Үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББББ-тэй болох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан		Хариуцлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	• Төлбөрийг дараа өгөхөөр 24,411.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа бүртгэлийг өглөг үүсгэхгүйгээр авлага бууруулах бичилт хийсэн нь УСНББОУС 12 болон Сангийн сайдын 100 дугаар журам, • Цалинг тооцон бүртгэхдээ тооцоолсон дүнгээр бүртгээгүй, илүү 8.610,0 мянган төгрөгөөр журнал бүртгэл хөтөлсөн, • Данс бүртгэлд тусгагдсан үндсэн хөрөнгийн 431,8 мянга төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу бүртгэсэн, 49,900.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого дутуу нь УСНББОУС 17		4	83353.7	4	83353.7								
2	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Гүйцэтгэх захирлын 2021.04.13-ны Б/21 тоот тушаалаар батлагдаагүй орон тоонд аж ахуйн нярав авч ажиллуулан 464.3 мянган төгрөгийн цалин олгосон байна.	Батлагдаагүй орон тооны ажилтанд олгосон 464.3 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох.	1	464.29			1	464.29						
3	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Илүү цагийн тооцоололд түүвэрлэн тооцоолоход ээлжийн бус 12 ажилтан албан хаагчид илүү цаг тооцон олгохдоо Засгийн зарын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3-ын 3-т зааснаас илүү олгосон байна	Илүү олгосон 977.0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох	1	997			1	997						
4	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Төрөөс үзүүлсэн хөнгөлөлтийн үнэ болох усны үнэ 3,734.0 мянган төгрөг, дулааны үнэ болох 25,965.4 мянган төгрөг, нийт 29,699.4 мянган төгрөгийг тухай бүр авлагаар бүртгэл хөтлөөгүй, жилийн эцэст үүссэн 3,936.9 мянган төгрөгөөр авлага үүсгэсэн байна.	Холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг таслан зогсоох	1	25762.4					1	25762.4				
5	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын А/7 тоот тушаалаар 12 дугаар сарын 28-нд дуусгахаар 4 хүний бүрэлдэхүүнтэй жилийн эцсийн тооллогын комиссыг томилжээ. Тооллогын дүнгээс үндсэн хөрөнгө 175,699.5 мянган төгрөгөөр, бараа материал 3,952.4 мянган төгрөгийн дутуу, тооллого хийснээс хойш бараа материал 11,925.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн нь тооллогыг үнэн зөв бодиттой хийгээгүй байна.	Холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг таслан зогсоох	1	0					1	0				
6	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс тайлант хугацаанд 6,584.2 мянган төгрөгийн авлага үүсэж, өмнөх онд үүссэн 4,100.6 мянган төгрөг, 4-5 жилийн насжилттай 9,228.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16.5.4-т заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	19913.2									1	19913.2
7	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Бараа материалыг орлогоор бүртгэхдээ эхний хагас жил НӨАТ орсон дүнгээр нярав орлого авч тайлагнасан байна.	Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын 4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	0									1	0

8	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс тайлант хугацаанд 2,223.3 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16.5.4-т заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	2223.3									1	2223.3
9	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Тайлант оны борлуулалтын өртгийг тооцохдоо үйлдвэрлэлд хамаарах зардлын дүнгээр бус зөвхөн бараа материалын зарцуулалт 105,642.3 мянган төгрөгөөр тодорхойлсон байна.	Холбогдох хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	68110.6									1	68110.6
10	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Дотоод журмын 6.2-т ажилтан албан хаагчдын цагийн бүртгэлийг тухайн сарын 25-нд гаргаж цалинг тооцоолж шилжүүлж тайлагнасан байна.	НББ-ийн тухай хуулийн 10.1, байгууллагын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	0									1	0
11	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Тус ОНӨААТҮГ нь өөр үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.	Үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББББ-тэй болох	1	0									1	0
			ДҮН		14	200824.5	4	83353.7	2	1461.3	2	25762.4	0	0	6	90247.1
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	ИТХ-аас төсөвт тодотгол хийгээгүй, гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 14-ний Б/26, 2021 оны 12 дугаар сарын 10-ны Б/21 дүгээр тушаалаар ажилчин албан хаагчдийг нийт 6,600.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон	Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг таслан зогсоох	1	5800					1	5800				
2	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Сахилгын шийтгэлтэй машинист болон цахилгаанчин 2 ажилтан албан хаагчдад 800.0 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосон	Шагнаж урамшуулсан 800.0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгох	1	800			1	800						
3	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Түүхий эд материал болох нүүрсийг "Баян тээг" ХХК-аас тайлант онд нийт 44,069.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн бөгөөд нүүрсний тээвэрлэлтэд нийт 123,205.6 мянган төгрөгийн тээврийн хөлс олгосон ч гүйцэтгэсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй гэрээ хийгээгүй шууд худалдан авалт хийсэн	Таслан зогсоох, хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах	1	167275					1	167275				
4	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	ИТХ-ын шийдвэргүйгээр 7,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл бэлтгэсэн нь байгууллагын дүрмийн 4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.	Таслан зогсоох, холбогдох хууль, дүрмийг бүрэн хэрэгжүүлж ажиллах	1	7800					1	7800				
5	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй худалдан авалт хийсэн, худалдан авагч 27 байгууллага, харилцагч 23 байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй	Таслан зогсоох, холбогдох хууль, дүрмийг бүрэн хэрэгжүүлж ажиллах	1	0					1	0				
6	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ	БУА-2022/1/НА-СТА-ТШЗ	Тайлант онд нийт 814,473.4 мянган төгрөгийн 84 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 16 удаагийн 176,178.8 мянган төгрөгийн орлого, 13 удаагийн 85,766.2 мянган төгрөгийн зарлага, 13 удаагийн 54,439.8 мянган төгрөгийн худалдан авалтын мэдээллийг ил тод байршуулаагүй	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан	1	0					1	0				
					0	0										
			ДҮН		6	181675	0	0	1	800	5	180875	0	0	0	0
			НИЙТ ДҮН		20	382499.5	4	83353.7	3	2261.3	7	206637.4	0	0	6	90247.1